



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Сайншанд сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/56/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
(Дорноговь аймаг, Сайншанд сум)
2020 он

Тэргүүлэх аудитор:	Ч.Ариунаа
Утас: 70522734	Цахим хаяг: ariunaa.ch@audit.gov.mn
Аудитын менежер:	Э.Энхцэцэг
Утас: 70523020	Цахим хаяг: enkhtsetseg.e@audit.gov.mn.
Аудитор:	Г.Энхтөр
Утас: 99032916	Цахим хаяг: ij17.audit@gmail.com

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан.....	5
2.1.	Оршил.....	5
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8.	Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	8
2.9.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.10.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	9
2.11.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.12.	Шилэн дансны мэдээлэл	10
2.13.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.14.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3	Менежментийн захидал.....	11
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	12

1 Аудитын гэрчилгээ


 ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 44103 Дорноговь аймаг, Сайншанд сум, 3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр, Утас: (705) 2-27-34 Вэб сайт: dornogovi@audit.gov.mn	ДОРНОГОВЬ АЙМГИЙН САЙНШАНД СУМЫН ХҮҮХДИЙН 2 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ Д.БОЛОРМАА ТАНАА
2020.02.28 № 1-6/256	
танай _____ -ны № _____ -т	
Аудитын гэрчилгээ	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу Дорноговь аймгийн Сайншанд сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.</p>	
Зөрчилгүй санал дүгнэлт	
<p>Дорноговь аймгийн Сайншанд сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.</p>	
Санал дүгнэлтийн үндэслэл	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.</p>	
<p>Аудитаар Дорноговь аймгийн Сайншанд сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.</p>	
<p>Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.</p>	

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Дорноговь аймгийн Сайншанд сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг цэцэрлэгийн эрхлэгч Д.Болормаад танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Сайншанд сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 30-наас 2020 оны 02 дугаар сарын 03-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 2 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын захиалгаар Ингүүмэл жаргалант аудит ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэг 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн

аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 05 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Дорноговь аймгийн Сайншанд сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэг нь бага насны хүүхдийг 21 дүгээр зуунд сурч хөгжин амьдрах, хөгжүүлэхэд туслах зорилгоор тэдэнд үзүүлэх үйлчилгээг хүртээмжтэй болгох, тэдний сурч, хөгжих ээлтэй орчин бүрдүүлэхэд нөөц боломжоо ашиглан ажиллах гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Байгууллагын үүсгэн байгуулах баримт бичигт үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сургуулийн өмнөх боловсрол олгох үйл ажиллагаа.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа эрх зүйн орчинд томоохон өөрчлөлт гараагүй.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд эрсдэлгүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн "Acoluos" санхүүгийн программ хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 36 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 2 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын 0.2 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь батлагдсан төсвийн дагуу үйл ажиллагааг санхүүжүүлж байгаа тул материаллаг байдлын сууриар нийт зардлыг сонгосонтой холбоотой юм.

2019 оны нийт зардал 413,132.7 мянган төгрөг бөгөөд түүний 0.2 хувь болох 826.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 0.2 хувиар тооцсон нь нэг удаагийн ажил гүйлгээний дүнг харгалзан үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дорноговь аймгийн Сайншанд сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 33,984.1 мянган төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	4,502.60	-	(4,502.60)
Авлага	81.00	1,272.00	1,191.00
Урьдчилгаа			-
Бараа материал	36,618.40	44,409.50	7,791.10
Үндсэн хөрөнгө	771,835.60	733,372.00	(38,463.60)
Нийт хөрөнгө	813,037.60	779,053.50	(33,984.10)
Өр төлбөр	45.80		(45.80)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	812,991.80	779,053.50	(33,938.30)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	813,037.60	779,053.50	(33,984.10)

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь мах нөөцлөх, хөгжмийн өрөөг эсгий хавтангаар доторлох, дулаан алдалт их байдаг учир вакум хаалт хийхээр оны эцэст 19,343.4 мянган төгрөгийн худалдан авалт хийсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь дээд байгууллагаас хөрөнгө мөнгийг шийдвэрлэж, төсөвт зохицуулалт хийлгэн хөрөнгө оруулалтаар 4,767.4 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй хүлээн авсан 162.0 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, ашиглах жилийн дагуу тайлант үеийн элэгдлийн зардлыг тооцоолсноос шалтгаалсан байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, өмнөх үед хамаарах алдааны залруулга хийгдээгүй байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2019 онд 382,535.00 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Нийт зардлын 355,203.7 мянган төгрөгийг улсын төсвөөс, 47,331.3 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 381,629.2 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа бөгөөд тайлант хугацаанд төсвийн хэтрэлт хэмнэлт гараагүй байна.

Нэмэлт төсөв: Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого болон нэмэлт санхүүжилт байхгүй.

2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 6 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар мөнгөн дүнгээр илэрхийлэгдээгүй 1 асуудлыг алдаа зөрчилд тооцон алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар ажлаас халагдсан ажилтны ээлжийн амралтын олговрыг хэрхэн тооцож байгаа шалгах нь зүйтэй байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Дорноговь аймгийн Сайншанд сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэг нь шилэн дансны нэгдсэн www.shilendans.gov.mn цахим хуудсанд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар 149 мэдээлэл байршуулахаас 149 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар нэг зөвлөмж өгөгдсөн бөгөөд 2019 оны жилийн эцсийн байдлаар зөвлөмжийн биелэлт 100 хувьтай байна.

2.14. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Сайншанд сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Дорноговь аймгийн Сайншанд сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Ээлжийн амралт олгох тухай мэдэгдлийг Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалаар баталсан зааврын дагуу хөтөлдөггүй байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг холбогдох нотлох баримтын хамт Төрийн аудитын байгууллагад 2020 оны 5 дугаар сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

3.1 Тухайн байгууллага, салбартай холбоотой хууль эрх зүйн орчин.

3.1.1 Илрүүлэлт:

Ээлжийн амралт олгох тухай мэдэгдлийг Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалаар баталсан зааврын дагуу хөтөлдөггүй байна.

Энэ нь үнэн зөв байх, бодитой оршин байх ба тодорхойлогдсон байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалыг зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Анхан шатны баримтыг батлагдсан маягтаар хөтлөхгүй байх, ээлжийн амралтын тооцоог зөрүүтэй тооцох.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалаар баталсан заавар, маягтын дагуу ээлжийн амралт олгох тухай мэдэгдлийг цэцэрлэгийн эрхлэгч хариуцан хөтлөх бөгөөд нягтлан бодогч уг мэдэгдлийг үндэслэн ээлжийн амралтын олговрыг тооцож холбогдох санхүүгийн баримтанд хадгална.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Санал байхгүй.

4 Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

4.1. Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31

Үзүүлэлт		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	41,202,051.22	45,681,455.36
2	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	4,502,648.00	-
8	Банкинд байгаа бэлэн мөнгө	4,502,648.00	-
9	Төгрөг	4,502,648.00	-
14	Нэмэлт санхүүжилтийн харилцах	4,502,648.00	-
27	АВЛАГА	81,000.00	1,272,000.00
28	Ажиллагсадтай холбогдсон авлага	81,000.00	-
34	Бусад авлага	-	1,272,000.00
35	Байгууллагаас авах авлага	-	1,272,000.00
60	БАРАА МАТЕРИАЛ	36,618,403.22	44,409,455.36
61	Түүхий эд материал	-	1,000,000.00
62	Тусгай зориулалттай материал	-	1,000,000.00
66	Хангамжийн материал	36,618,403.22	43,409,455.36
67	Бичиг хэргийн материал	766,022.00	676,615.00
68	Аж ахуйн материал	28,012,037.22	28,579,031.36
71	Барилгын засварын материал	1,116,550.00	4,739,031.00
72	Хүнсний материал	2,773,315.00	5,647,800.00
73	Бусад хангамжийн материал	3,950,479.00	3,766,978.00
86	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	771,835,592.36	733,372,043.98
106	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	771,835,592.36	733,372,043.98
108	Биет хөрөнгө	720,171,592.36	681,708,043.98
109	Барилга, байгууламж	677,554,914.69	677,554,914.69
110	Хуримтлагдсан элэгдэл	-	(34,298,308.32)
113	Машин, тоног төхөөрөмж	54,777,803.00	59,427,703.00
114	Хуримтлагдсан элэгдэл	(35,289,688.34)	(39,893,909.12)
115	Тавилга, аж ахуйн эд хогшил	37,482,041.40	37,482,041.40
116	Хуримтлагдсан элэгдэл	(23,002,894.19)	(26,270,279.87)
122	Бусад үндсэн хөрөнгө	9,802,263.44	9,802,263.44
123	Хуримтлагдсан элэгдэл	(3,106,894.30)	(4,329,931.90)
125	Номын фонд	1,954,046.66	2,233,550.66
126	Биет бус хөрөнгө	51,664,000.00	51,664,000.00
127	Програм хангамж	1,399,500.00	1,399,500.00
128	Хасагдуулга	(1,399,500.00)	(1,399,500.00)
129	Бусад биет бус хөрөнгө	51,664,000.00	51,664,000.00
137	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	813,037,643.58	779,053,499.34
138	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	45,810.50	-
139	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	45,810.50	-
164	Өглөг	45,810.50	-
165	Ажиллагчидтай холбогдсон өглөг	42,810.50	-
170	Бусад өглөг	3,000.00	-
171	Байгууллагад төлөх өглөг	3,000.00	-
214	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	812,991,833.08	779,053,499.34
215	Засгийн газрын хувь оролцоо	812,991,833.08	779,053,499.34
216	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	201,519,283.44	201,519,283.44
217	Өмч: -Төрийн өмч	201,519,283.44	201,519,283.44
223	Хуримтлагдсан үр дүн	139,359,718.47	105,421,384.73
224	Өмнөх үеийн үр дүн	139,359,718.47	134,857,070.47
225	Тайлант үеийн үр дүн	-	(29,435,685.74)
227	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	472,112,831.17	472,112,831.17

231 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН** | **813,037,643.58** | **779,053,499.34**

4.2. Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31

Үзүүлэлт		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	311,523,514.66	383,697,000.00
76	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	116,466.66	1,162,000.00
77	Нийтлэг татварын бус орлого	116,466.66	1,162,000.00
81	Төсөвт байгууллагын өөрийн орлого	116,466.66	1,162,000.00
86	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	116,466.66	1,162,000.00
111	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,413,148.00	47,331,300.00
119	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	303,993,900.00	335,203,700.00
122	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,413,148.00	-
126	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагч	7,413,148.00	-
129	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	47,331,300.00
130	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	47,331,300.00
147	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	330,510,722.11	413,132,685.74
148	УРСГАЛ ЗАРДАЛ	330,510,722.11	413,132,685.74
149	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	324,151,204.11	412,126,909.16
150	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	191,441,660.75	237,760,278.00
151	Цалин	173,710,660.75	192,217,937.00
152	Нэмэгдэл цалин	6,592,000.00	26,782,996.00
153	Унаа хоолны хөнгөлөлт	-	2,946,000.00
154	Урамшуулал	11,139,000.00	15,813,345.00
157	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,699,259.28	30,537,774.26
158	Тэтгэврийн даатгалын шимтгэл	22,699,259.28	20,955,022.76
159	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	-	1,852,569.00
160	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	-	2,395,687.00
161	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	-	543,118.00
162	Эрүүл мэндийн даатгалын хураамж	-	4,791,377.50
164	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,678,000.00	39,909,181.66
165	Гэрэл цахилгааны зардал	8,647,012.00	4,917,862.06
166	Түлш, халаалтын зардал	21,485,772.00	30,033,879.60
167	Цэвэр, бохир усны зардал	4,545,216.00	4,957,440.00
170	Хангамж, бараа материалын зардал	6,090,866.12	7,620,611.86
171	Бичиг хэргийн материал	1,151,060.00	1,194,097.00
172	Тээвэр, шатахууны зардал	30,000.00	190,000.00
173	Шуудан холбоо интернэтийн төлбөр	290,460.00	130,496.00
174	Ном, хэвлэлийн зардал	70,600.00	10,800.00
175	Хог хаягдал устгах, цэвэрлэх	-	189,000.00
176	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	973,890.00	1,258,283.00
178	Бараа материал акталсны зардал	3,574,856.12	4,647,935.86
181	Нормативт зардал	45,962,175.00	48,196,888.00
182	Эм	75,560.00	75,300.00
183	Хоол	45,638,045.00	48,121,588.00
184	Нормын хувцас, зөөлөн эдлэл	248,570.00	-
185	Эд хогшил, урсгал засварын зардал	3,200,388.40	3,299,423.00

Дорноговь аймгийн Сайншанд сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

189	Урсгал засвар	3,200,388.40	3,299,423.00
190	Томилолт, зочны зардал	90,000.00	150,000.00
192	Дотоод томилолтын зардал	90,000.00	150,000.00
194	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	872,270.00	910,000.00
195	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	872,270.00	850,000.00
196	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	-	60,000.00
209	Бараа үйлчилгээний бусад зардал	19,116,584.56	43,742,752.38
210	Бараа үйлчилгээний бусад зардал	219,000.00	-
211	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	785,090.00	349,800.00
212	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	18,112,494.56	43,392,952.38
224	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,359,518.00	1,005,776.58
225	Засгийн газрын урсгал шилжүүлэг	580,518.00	905,776.58
226	Төвлөрүүлэх шилжүүлэг	580,518.00	905,776.58
228	Бусад урсгал шилжүүлэг	5,779,000.00	100,000.00
235	Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	5,379,000.00	-
236	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	400,000.00	100,000.00
268	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III-I-II)	(18,987,207.45)	(29,435,685.74)
288	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	(18,987,207.45)	(29,435,685.74)

4.3. Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31

Үзүүлэлт		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	311,407,048.00	382,535,000.00
110	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	311,407,048.00	382,535,000.00
118	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	303,993,900.00	335,203,700.00
121	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,413,148.00	-
125	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагч	7,413,148.00	-
129	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	47,331,300.00
130	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	47,331,300.00
147	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	304,714,600.00	377,767,596.00
148	УРСГАЛ ЗАРДАЛ	304,714,600.00	377,767,596.00
149	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	298,355,082.00	376,761,819.42
150	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	190,660,900.00	238,292,200.00
151	Үндсэн цалин	172,929,900.00	187,493,019.50
152	Нэмэгдэл	6,592,000.00	28,746,352.00
153	Унаа хоолны хөнгөлөлт	-	4,158,800.00
154	Үр дүнгийн урамшуулал	11,139,000.00	17,894,028.50
157	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,367,027.00	29,964,592.76
158	Тэтгэврийн даатгалын шимтгэл	24,367,027.00	21,612,433.00
159	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	-	2,388,233.00
160	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	-	1,910,587.00
161	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	-	450,000.00
162	Эрүүл мэндийн даатгалын хураамж	-	3,603,339.76
164	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	34,678,000.00	39,909,181.66
165	Гэрэл цахилгааны зардал	5,066,050.00	4,917,862.06
166	Түлш, халаалтын зардал	25,066,734.00	30,033,879.60

Дорноговь аймгийн Сайншанд сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

167	Цэвэр, бохир усны зардал	4,545,216.00	4,957,440.00
170	Хангамж, бараа материалын зардал	3,179,200.00	5,047,996.00
171	Бичиг хэрэг	958,950.00	96,700.00
172	Тээвэр, шатахуун	60,000.00	160,000.00
173	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	114,930.00	130,496.00
174	Ном, хэвлэл	95,500.00	10,800.00
175	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	150,000.00	189,000.00
176	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,799,820.00	4,461,000.00
181	Нормативт зардал	40,807,455.00	51,810,973.00
182	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	75,300.00	75,300.00
183	Хоол, хүнс	39,995,825.00	50,999,073.00
184	Нормын хувцас, зөөлөн эдлэл	736,330.00	736,600.00
185	Эд хогшил, урсгал засварын зардал	2,165,200.00	9,376,886.00
186	Багаж техник хэрэгсэл	110,200.00	2,622,000.00
189	Урсгал засвар	2,055,000.00	6,754,886.00
190	Томилолт, зочны зардал	90,000.00	150,000.00
192	Дотоод албан томилолт	90,000.00	150,000.00
194	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	887,300.00	910,000.00
195	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	887,300.00	850,000.00
196	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	60,000.00
208	Бараа үйлчилгээний бусад зардал	1,520,000.00	1,299,990.00
209	Бараа үйлчилгээний бусад зардал	219,000.00	-
210	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,301,000.00	1,299,990.00
221	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,359,518.00	1,005,776.58
222	Засгийн газрын урсгал шилжүүлэг	580,518.00	905,776.58
223	Төвлөрүүлэх шилжүүлэг	580,518.00	905,776.58
225	Бусад урсгал шилжүүлэг	5,779,000.00	100,000.00
232	Хөдөө орон нутагт тогтвортой ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	5,379,000.00	-
233	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	400,000.00	100,000.00
250	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	6,692,448.00	4,767,404.00
251	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
261	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	2,189,800.00	4,767,404.00
262	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,189,800.00	4,767,404.00
263	Дотоод эх үүсвэрээр	2,189,800.00	4,767,404.00
275	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,189,800.00	4,767,404.00
278	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(2,189,800.00)	(4,767,404.00)
279	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
303	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	4,502,648.00	-
304	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	4,502,648.00
305	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,502,648.00	-

4.4. Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31

	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2	2018 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	149,855,283.44	472,112,831.17	158,346,925.92	780,315,040.53
3	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
4	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	149,855,283.44	472,112,831.17	158,346,925.92	780,315,040.53
5	Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн				-
6	Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз				-
7	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз				-
8	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	51,664,000.00		(18,987,207.45)	32,676,792.55
9	2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	201,519,283.44	472,112,831.17	139,359,718.47	812,991,833.08
10	2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	201,519,283.44	472,112,831.17	139,359,718.47	812,991,833.08
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			(4,502,648.00)	(4,502,648.00)
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	201,519,283.44	472,112,831.17	134,857,070.47	808,489,185.08
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				-
14	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				-
15	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз				-
16	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				-
17	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/			(29,435,685.74)	(29,435,685.74)
18	2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	201,519,283.44	472,112,831.17	105,421,384.73	779,053,499.34

4.5. Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31

	Үзүүлэлт	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	382,535,000.00	381,629,223.42	905,776.58	99.76
3	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	382,535,000.00	381,629,223.42	905,776.58	99.76
4	Бараа, үйлчилгээний зардал	382,435,000.00	381,529,223.42	905,776.58	99.76
5	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	238,292,200.00	238,292,200.00	-	100.00
6	Үндсэн цалин	183,570,400.00	187,493,019.50	(3,922,619.50)	102.14
7	Нэмэгдэл	28,951,900.00	28,746,352.00	205,548.00	99.29
8	Унаа, болон бусад нөхөн олговор	4,929,700.00	4,158,800.00	770,900.00	84.36
9	Урамшуулал	20,840,200.00	17,894,028.50	2,946,171.50	85.86
11	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,203,000.00	29,964,592.76	238,407.24	99.21
12	Тэтгэврийн даатгал	18,917,300.00	21,612,433.00	(2,695,133.00)	114.25
13	Тэтгэмжийн даатгал	4,084,800.00	2,388,233.00	1,696,567.00	58.47
14	ҮОМШӨ ний даатгал	2,250,300.00	1,910,587.00	339,713.00	84.90
15	Ажилгүйдлийн даатгал	450,000.00	450,000.00	-	100.00
16	Эрүүл мэндийн даатгал	4,500,600.00	3,603,339.76	897,260.24	80.06
17	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,576,300.00	39,909,181.66	667,118.34	98.36
18	Гэрэл цахилгаан	5,136,000.00	4,917,862.06	218,137.94	95.75
19	Түлш, халаалт	30,033,900.00	30,033,879.60	20.40	100.00
20	Цэвэр, бохир ус	5,406,400.00	4,957,440.00	448,960.00	91.70
22	Хангамж, бараа материалын зардал	5,165,500.00	5,165,500.00	-	100.00
23	Бичиг хэрэг	96,700.00	96,700.00	-	100.00
24	Тээвэр (шатахуун)	160,000.00	160,000.00	-	100.00
25	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	73,400.00	130,496.00	(57,096.00)	177.79
26	Ном, хэвлэл	185,400.00	128,304.00	57,096.00	69.20
27	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	300,000.00	189,000.00	111,000.00	63.00
28	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	4,350,000.00	4,461,000.00	(111,000.00)	102.55
30	Нормативт зардал	51,811,000.00	51,810,973.00	27.00	100.00
31	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	75,300.00	75,300.00	-	100.00
32	Хоол, хүнс	50,999,100.00	50,999,073.00	27.00	100.00
33	Нормын хувцас зөөлөн эдлэл	736,600.00	736,600.00	-	100.00
34	Эд хогшил худалдан авах	14,027,000.00	14,026,786.00	214.00	100.00
35	Багаж, техник, хэрэгсэл	7,272,000.00	7,271,900.00	100.00	100.00
38	Урсгал засвар	6,755,000.00	6,754,886.00	114.00	100.00
39	Томилолт, зочны зардал	150,000.00	150,000.00	-	100.00
41	Дотоод албан томилолт	150,000.00	150,000.00	-	100.00
43	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	910,000.00	910,000.00	-	100.00
44	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	850,000.00	850,000.00	-	100.00
45	Аудит, баталгаажуулалт зэрэглэл	60,000.00	60,000.00	-	100.00

Дорноговь аймгийн Сайншанд сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	тогтоох зардал				
53	Бараа үйлчилгээний бусад зардал	1,300,000.00	1,299,990.00	10.00	100.00
55	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,300,000.00	1,299,990.00	10.00	100.00
66	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	100,000.00	100,000.00	-	100.00
70	Бусад урсгал шилжүүлэг	100,000.00	100,000.00	-	100.00
78	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	100,000.00	100,000.00	-	100.00
97	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	382,535,000.00	382,535,000.00	-	100.00
98	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	335,203,700.00	335,203,700.00	-	100.00
101	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	335,203,700.00	335,203,700.00	-	100.00
103	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	47,331,300.00	47,331,300.00	-	100.00
104	Орон нутгийн төсвөөс	47,331,300.00	47,331,300.00	-	100.00
127	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
128	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
129	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
130	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
133	АЖИЛЛАГСДЫН ТОО	23	23	-	100.00
134	Удирдах ажилтан	1	1	-	100.00
135	Гүйцэтгэх ажилтан	14	14	-	100.00
136	Үйлчлэх ажилтан	8	8	-	100.00
138	СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/	-	-	-	-